

**“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ, ТУЗ-ИЙН АЖИЛ  
БОЛОН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН**

**НЭГ. 2016 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**


**1. 2016 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ЗОРИЛТ ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ**

2016 оны уулын ажил компанийн ТУЗ-ийн хурлаар батлуулж АМГ-аар хянан баталгаажуулсан төлөвлөгөөний дагуу явагдсан бөгөөд 2016-2017 онд өвлийн оргил ачаалалтай үед олборлох нүүрсний нөөц нээн ачиж борлуулах, онд шилжих нүүрсний нөөц бэлтгэх, уурхайн уулын ажлын цаашдын өрнөлтийн чиглэлийг бататгах зэрэг үндсэн зорилтыг хангаж ажиллаа.

2016 онд уулын ажлын зохион байгуулалтын хувьд гол хийгдсэн ажил гэвэл уурхайн Төвийн урд блокийн болон Хойд блокийн гарш хэсгийн хөрс хуулалтыг түлхүү явуулж дулааны станцуудад нийлүүлэх нүүрсний нөөцөөр тасалдалгүй ханган 2017 онд 150.0мян.тн нээгдсэн нүүрсний нөөцтэй шилжсэн болон ус шүүрүүлэлтийн хуучин малталтыг онгойлгож улны усны төвшинг буулгасан түүнчлэн ил уурхайн мөрөгцөг, зам талбай, овоолгын технологийн паспортыг мөрдүүлж уурхайн дизайн зохион байгуулалтыг сайжруулсан зэрэг онцлог ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн явдал юм.

Энэ оны нүүрс олборлолтын төлөвлөгөө тасалдахад худалдан авахаар төлөвлөгдсөн зарим хэрэглэгчдийн санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой төлбөрийн хүндрэл, тэдгээрийн үйлдвэрлэлийн зогсолт саатал, нүүрс худалдан авалтаа багасгасан зэрэг гадаад хүчин зүйлүүд нөлөөлсөн болно. Харин хөрс хуулалтын төлөвлөгөө тасалдахад тээвэрлэлтийн машин болон экскаваторуудын эвдрэл саатлаас шалтгаалсан сул зогсолт гарсан нь голлон нөлөөлсөн байна.

2016 онд нүүрсний чанарын хяналтыг сайжруулж ажилласан бөгөөд нийт нүүрсний 72,3 хувийг Төвийн урд блокоос, 13,4 хувийг Хойд блокийн гарш хэсгээс болон Өмнөд блокоос тус тус, 0,9 хувийг Хойд улны хэсгээс олборлосон байна. Уул техникийн нөхцөлийн хувьд Өмнөд блокийн хөрсний гулсалттай холбоотой уг блокийн ажлыг зогсоосон, Төвийн болон Хойд блокийн нүүрсний давхаргын чулууны үе нэмэгдсэн, овоолгын орон зайн хязгаарлагдмал байдал зэрэг онцлог хүндрэл уулын ажилд нөлөөлж байлаа.



**Төвийн хойд блок**

төл. 2160.0 м.м3 гүй. 556.6 м.м3  
төл. 0 м.тн гүй. м.тн

**Хойд ул**

төл. 0 м.м3 гүй. 6.8 м.м3  
төл. 0 м.тн гүй. 7.0 м.тн  
0.97

**Хойд блок гарш**

төл. 1005.0 м.м3 гүй. 2311.0 м.м3  
төл. 195.0 м.тн гүй. 102.0 м.тн  
5.2 22.6

**Төвийн урд блок**

төл. 2230.0 м.м3 гүй. 1225.6 м.м3  
төл. 311.0 м.тн гүй. 551.0 м.тн  
5,54 2.22

**Өмнөд блок**


төл. 1510.0 м.м3 гүй. 240.5 м.м3  
төл. 377.0 м.тн гүй. 101.8 м.тн  
4.0 2.36

Зураг.№1 Уулын ажлын төлөвлөгөөт үзүүлэлтийн гүйцэтгэлийг талбайн байрлал блок тус бүрээр үзүүлэв.

**Уулын ажлын төлөвлөгөөт үзүүлэлтийн гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Нэгж	2015 он	2016 он		2015 онтой харьцуулсан үзүүлэлт
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нүүрс олборлолт	м.тн	758.5	883.0	761.9	100.4%
2	Нүүрс борлуулалт	м.тн	758.4	855.2	753.7	99.4%
3	Хөрс хуулалт	м.м <sup>3</sup>	4570.0	6905.0	4340.3	94.9%
	Тээвэртэй	м.м <sup>3</sup>	3796.5	5885.0	4102.3	108.1%
	Тээвэргүй	м.м <sup>3</sup>	773.5	1020.0	238.0	30.8%
4	Уулын цул	м.м <sup>3</sup>	5153.5	7584.2	4926.4	95.6%
5	Шидэлт	м.м <sup>3</sup>	202.8	180.0	672.7	331.7%
6	Өрөмдлөг	м.у.м	56.4	60.0	64.0	113.5%
7	Тэсрэх материал	м.тн	455.5	450.0	557.1	122.3%
8	Тэсэлсэн уулын цул	м.м <sup>3</sup>	1143.1	1100.0	1234.4	107.9%
9	Х.Х.Коэффициент	м <sup>3</sup> /тн	6.03	7.8	5.7	

2016 онд Ил уурхайд хийгдсэн тэсэлгээний ажлын блокуудад эзлэх хувь



2016 онд Ил уурхайд хийгдсэн тэсэлгээнд хэрэглэсэн тэслэх материалын хэмжээ

2016 он	Төлөвлөгөө /тн/		Гүйцэтгэл /тн/		Гүйцэтгэл /м <sup>3</sup> /
	Анфо	Эмульс	Анфо	Эмульс	Уулын цул
	260,0	190,0	291,4	267,7	1234,4
<b>Нийт</b>	<b>450,0</b>		<b>557,1</b>		



2. НҮҮРСНИЙ НӨӨЦ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

2016 оны нүүрсний блокуудын нөөцийн хөдөлгөөний мэдээлэл

д/д	Блокын нэр	2016-01-01 нөөц /мян.тн/	2016 онд олборлосон хэмжээ	2017-01-01 нөөц /мян.тн/
1	Хойд блокын гарш хэсэг	230.0	102.0	446.3
2	Төв блокын урд хэсэг	1116.1	551.0	565.1
3	Өмнөд блок	481.4	101.8	379.6
	<b>Дүн</b>			<b>1391.0</b>

Дархан, Эрдэнэт ДЦС-уудад нийлүүлсэн нүүрсний чанарын үзүүлэлт






Хэрэглэгчид	Үзүүлэлт	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Дундаж
	Эрдэнэт	Чийг	14.8	14.9	14.8	13.4	12.6	12.8		12.5	13.6	15.4	15.4	
Үнслэг		22.6	20.6	23	27.7	26	27		26.2	23.8	24.8	25.1	27.5	<b>24.9</b>
Дөглөмхий		44.2	44.2	44.7	45.6	45.7	45.8		46.1	45.2	46	46.1	44.5	<b>45.3</b>
Илчлэг		<b>4391.4</b>	<b>4391.7</b>	<b>4119.3</b>	<b>3900.6</b>	<b>4038.8</b>	<b>3891.5</b>		<b>4045</b>	<b>4148</b>	<b>3902.5</b>	<b>3945.6</b>	<b>3909.3</b>	<b>4062.2</b>
Дархан	Чийг	14.6	14.6	14.1	13.3	12.1	12.8	14.9	12.4	13.4	14.7	14.7	14.9	<b>13.9</b>
	Үнслэг	23.4	21.5	24.9	28	26.5	29.2	28.2	27.1	24.2	25.5	27.7	26.7	<b>26.1</b>
	Дөглөмхий	44.7	44.5	45.3	45.8	45.9	46.5	46.4	46.4	45.5	46.5	46.9	45.1	<b>45.8</b>
	Илчлэг	<b>4170.9</b>	<b>4339.1</b>	<b>4057.6</b>	<b>3883.3</b>	<b>3958.8</b>	<b>3774</b>	<b>3678.9</b>	<b>3992.3</b>	<b>4143</b>	<b>3969.5</b>	<b>3834.3</b>	<b>3903</b>	<b>3975.4</b>

Дээр дурдсан хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанар стандарттай нүүрсээр хангахын тулд нүүрсний 3 өөр блокуудаас өөр хооронд нь холилт хийн нүүрсний чанарыг тогтвортой түвшинд барьсан.



### 3. НҮҮРС БОРЛУУЛАЛТЫН ТАЛААР

№	Харилцагч	Дундаж үнэ /төг/	Нийт
1	Эрчим хүч	36,524	588.6
2	VIP	55,762	97.7
3	Гэрээт: ЖДҮ	48,193	23.2
4	Гэрээгүй: Хувь хүн	80,000	3.3
5	Жижиглэн	78,855	39.1
6	ШГ: Хямдралтай	42,402	3.9
	Дүн /тонн/		755.4






#### 4. ТЕХНИКИЙН АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

2016 онд Ил уурхайн уулын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдсан үндсэн тоног төхөөрөмжийн төрөл, тоо хэмжээ, ашигласан хугацааны мэдээллийг хүснэгтэд үзүүлэв.

№	Техникийн төрөл	Марк тип	Тоо ширхэг	Ашигласан хугацаа /жил/
1	Цахилгаан экскаватор	ЭКГ-4У, ЭКГ-8И, ЭКГ-5А	5	26-29
2	Алхагч экскаватор	ЭШ-10/70	1	37
3	Автосамосвал	HD465-7R	7	4
4	Автомашин	Nord Benz	3	4
5	Автосамосвал	Doosan DA-40	-	-
6	Өрөм	Sandvik DI-550	1	4
7	Илчит тэрэг	ТЭМ-2	1	10
8	Бульдозер түрэгч	Чанту SD-32, Коматцу 155А	3	5-10
9	Хусагч грейдер	CAT-16G, GD-655	2	1-23
10	Гинжит гидро экскаватор	Doosan DX-500,520,700	3	3-4
11	Дугуйт ачигч экскаватор	Doosan SD-200, SD-300	2	2-3
12	Зам усалгааны машин	ХОВО	1	7
13	Технологийн дамжлага	ЗХУ-ын комплекс	1	37



Техникийн засварын газрын тоноглол, хүчин чадал, зохион байгуулалтыг сайжруулсанаар гадны байгууллагаар хийлгэсэн засварын ажлын зардал нэлээд багассан байна.



Тосолгоо үйлчилгээг зориулалтын машинаар, карьерт хийх болсноор гарсан үр ашиг




Цахилгаан болон гидро экскаваторуудын 1м.куб уулын цулд ачихад зарцуулсан сэлбэг, шатах тослох материалын зардал. (төгрөг)

Гүйцэтгэсэн ажил: Гидро экс. 2394137 м.куб  
Цахилгаан экс. 3066500 м.



УУРХАЙН ТЭЭВЭР ХИЙЖ БАЙГАА АВТОСАМОСВАЛЫН 1М.КУБ УУЛЫН ЦУЛ ТЭЭВЭРЛЭХЭД ЗАРЦУУСАН СЭЛБЭГ, ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ





## 5. 2016 ОНД ЦАХИЛГААН ХАНГАМЖИД ХИЙГДСЭН АЖЛУУДААС

- 2016 оны 8-р сард Буянтын ордыг ашиглах зорилгоор өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын 0.6 км бетонон тулгууртай шугам барьж холбогдох зөвшөөрөл бичиг баримтыг бүрдүүлэн ашиглалтанд оруулав.
- Технологи дамжлагын бутлуурын өндөр хүчдэлийн 250квт цахилгаан хөдөлгүүрийн удирдлаганд ВВТЭ-М-10/630 маркийн вакуум таслуур тавьснаар аюулгүй ажиллагаа болон цахилгаан тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа хангагдсан.
- ОХУ-ын "REM and COIL" ХХК-иас Синхрон болон тогтмол гүйдлийн цахилгаан хөдөлгүүрийн 6 төрлийн секц нийлүүлэгдэж засвар үйлчилгээнүүдийг хийснээр цахилгаан экскаваторуудын хөдөлгүүрээс шалтгаалсан зогсолт саатлууд эрс багассан


2016 оны Цахилгаан эрчим хүчний хэрэглээ үндсэн хэрэглэгч тус бүрээр				
Хэрэглэгч	Дугаар	Төлөвлөгөө мян.квтц	Гүйцэтгэл мян.квтц	Зөрүү
ЭШ-10/70А	№28	714.00	926.45	+ 212.45
ЭКГ-8И	№38	693.00	535.46	- 157.54
ЭКГ-4У	№37	630.50	658.07	+ 27.57
	№39	693.00	534.42	- 158.58
ЭКГ-5А	№42	499.05	498.50	- 0.55
	№20	55.0	52.8	- 2.2
Технологи дамжлага		620.8	607.69	- 13.11
Ус шүүрүүлэх		1536.4	2024.84	+ 488.44
Нүүрс баяжуулах		688	172.48	- 515.52
Дүн		6129.75	6010.71	- 119.04
Бусад		1456.25	1839.05	+ 382.8
Нийт дүн		7586.00	7849.76	+ 263.76



2016 онд цахилгаан хөдөлгүүрт гарсан эвдрэлийн шалтгаан

Төлөвлөгөөт үзлэг үйлчилгээ хийдэггүй	7%
Ороомгын тусгаарлах чадвараас	60%
Механик эвдрэлээс	25%
Хувь хүнээс шалтгаалсан	2%
Цахилгаан хөдөлгүүрийн насжилтаас	6%

Цахилгаан эрчим хүч зарцуулалт сүүлийн 3 жилийн төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалт



Төлөвлөгөө мян.квтцаг	Гүйцэтгэл мян.квтцаг	Төлөвлөгөө мян.квтцаг	Гүйцэтгэл мян.квтцаг	Төлөвлөгөө мян.квтцаг	Гүйцэтгэл мян.квтцаг
7374.3	7566.34	8021.81	7202.34	7586	7849.76

2016 оны гүйцэтгэл 3,47%-иар өссөн нь Буянтын алтны талбайд ЦЭХүч төлөвлөөгүй байсантай холбоотой.

## 6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР


### ХАБЭА–н ажлын нийт зардал



№	Зардлын төрөл	Төлөвлөсөн /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
1	Ажлын байруудын тэмдэг тэмдэгжүүлэлт	7,06	1,54
2	ГАА –г хангах, гамшгийн нөөц бүрдүүлэлт	11,79	4,84
3	ХАБЭА –н чиглэлээр явуулах сургалтын зардал	32,67	5,11
4	Хувцас, хамгаалах хэрэгслийн зардалд	326,82	134,92
5	Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөлт	52,53	15,86
7	Замын АА -ны хэрэгслүүд	8,05	2,81
8	Эрүүл ахуйн зардалд	8,50	0.71
	Дүн	447,42	165,16

## Осол, тохиолдлын судалгаа

Тохиолдлын төрлүүд	2015	2016
ОДТ	6	4
ЭТАГ	1	5
ХАГ	7	5
ӨАШГ	0	0
АОТ	2	3
ГТ	2	1
ӨЭТ	6	5
Алкохол	20	16



### ТАЙЛБАР:

- ОДТ ----- Осолд дөхсөн тохиодол
- ЭТАГ ----- Эмнэлэгийн тусламж авсан гэмтэл
- ХАГ ----- Хугацаа алдсан гэмтэл
- ӨАШГ ----- Өөр ажилд шилжүүлсэн гэмтэл
- АОТ ----- Авто ослын тохиолдол
- ГТ ----- Галын тохиолдол
- ӨЭТ ----- Өмчийн эвдрэлийн тохиолдол
- Алкохол ---- Архины зөрчил

## **7. ДОТООД ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2016 онд ДХА-аас хийж гүйцэтгэхээр 98 ажил төлөвлөснөөс 72 ажил бүрэн биелж, 11 ажил хагас биелж, 15 ажил санхүүгийн байдлаас болж хойшлогдлоо. Төлөвлөгөөний биелэлт 84,6% байна. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлага хангасан ажлын байр, техник, тоног төхөөрөмж, холбоо, шатахуун, бичиг хэргийн зардлыг бүрэн шийдвэрлүүлэв.

- Компанийн үйл ажиллагаанд өдөр тутам болон урт хугацаанд ашиглагддаг төрөл бүрийн журам, заавруудын ашиг, хэрэглээ болон давхцал зэргийг судлан бүртгэж 60 журам зааврыг шинэчлэн цэгцэлж, 26 журам зааврыг шинээр боловсруулж, батлуулан, мөрдөлтөнд хяналт тавин ажилллаж байна.
- Байгаль орчинд нөлөөлөх хүчин зүйлийг бууруулах чиглэлээр удирдамжтай шалгалт 6 удаа зохион байгуулж, 28 зөрчил дутагдал илрүүлж санхүү хөрөнгө мөнгө шаардлагатай 3 асуудлыг компанийн удирдлагад танилцуулж шийдвэр гаргууллаа.
- Ажил үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр удирдамжтай шалгалт 8 удаа хийж, 55 зөрчил илрүүлж 8 албан мэдэгдэл өглөө.
- Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хөдөлмөрийн дотоод журамтай холбогдсон удирдамжтай 23 шалгалт хийж, 97 зөрчил илрүүлж 56-г газар дээр нь засуулж ажил хариуцсан холбогдох албан тушаалтнуудад давхардсан тоогоор 28 мэдэгдэл шаардлага өгч 97 %-д хариу авлаа.
- Компанийн өмч хөрөнгийн хамгаалалт, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангах, сахилга бат, ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор “Би-Си-Ти” ХХК-тай гэрээ байгуулж 25 цэгт хяналтын камер суурьлуулж Дотоод Хяналтын алба болон хэлтэс албадын дарга нар өдөр тутмын хяналт тавьж байна.
- Гэрээт харуул хамгаалалтын албан хаагчдын сонор сэрэмж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн аюулгүй байдал хэвийн нөхцлийг хангаж ажиллах талаар 4 удаа зааварчлага өгч өдөр, шөнийн цагаар 26 удаа гэнэтийн шалгалт хийж 14 зөрчил илрүүлж, 6 албан мэдэгдэл өгч хамтарсан шалгалт 22 удаа зохион байгууллаа.




Шалгагдсан чиглэл, хяналтын хуудасны дугаар	2015 оны эхний хагас Үнэлгээ	2016 оны эхний хагас Үнэлгээ
Дулааны цахилгаан станц, уурын зуух 100 квт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуухны байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах ХХ-2.3	Шалгагдаагүй	82,5% буюу “Их эрсдэлтэй”
Бага хүчин чадлын зуухны үйл ажиллагааг шалгах ХХ-5.30	55% буюу “Их эрсдэлтэй”	26,7% буюу “Бага эрсдэлтэй”
Ил уурхайн үйл ажиллагааг шалгах ХХ-2.6	39% буюу “Бага эрсдэлтэй”	22,7% буюу “Бага эрсдэлтэй”
Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах ХХ-2.4	45% буюу “Бага эрсдэлтэй”	15,6% буюу “Бага эрсдэлтэй”
Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагыг шалгах ХХ-2.12	Шалгагдаагүй	8,8% буюу “Бага эрсдэлтэй”
Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах ХХ-4.1.1	36% буюу “Дунд эрсдэлтэй”	12,8% буюу “Бага эрсдэлтэй”
Хэмжүүр, хэмжих хэрэгслийн нэгдмэл байдлыг шалгах ХХ-5.28.1	29,5% буюу “Дунд эрсдэлтэй”	17,8% буюу “Бага эрсдэлтэй”
Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах ХХ-4.2	Шалгалт хийгдээгүй	9,9% буюу “Бага эрсдэлтэй”


## 8. БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

Техникийн нөхөн сэргээлтээр Уурхайн баруун жигүүрийн сул орон зайд 4,1 сая.м<sup>3</sup> хөрс дүүргэлт хийх юм. Үүнээс 2016 онд авто тээврээр болон Экс 10/70 –аар зам нээн шидэлт хийж 443,0 мян.м<sup>3</sup> буюу 3,0 га газар дүүргэлт хийлээ. Мөн доод хэсгийн бульдозерийн овоолгод ажлын бус хажуу болон баруун жигүүрийн суларсан орон зайд дүүргэлт хийж байна.





## 9. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ, ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ТАЛААР



### Нийгмийн хариуцлагын талаар 2016 онд хийсэн ажил

- Шарын голын ард иргэдэд нүүрсний хөнгөлөлт үзүүлэх.
- Шарын гол суманд шинээр байгуулагдсан цэцэрлэгт хандив өгсөн.
- Дархан –Уул аймгийн сургуулийн номын сангийн тохижилтонд хандив өгсөн.
- Дархан–Уул аймгийн амьжиргааны доод түвшиний ахмадуудад нүүрсний буцалтгүй тусламж үзүүлсэн /450 мянга төгрөг/.
- МШӨ–нөөс шалтгаалсан нөхөн олговрын 10 хүний өргөдөл гомдолд 36.0 сая төгрөг,
- Буцалтгүй тусламж 24 хүний өргөдөл гомдолд 13.9 сая төгрөг.
- Ахмад уурхайчдаа жил тутам хүлээж авч хүндэтгэл үзүүлдэг.
- Шарын гол сумын хоккейн багт 2.4 сая төгрөгөөр ивээн тэтгэв.
- Шарын гол сумд зохион байгуулагдсан Ахмадын хоккейн тэмцээнийг ивээн тэтгэв.



### Сургалтын албаны ажлын тайлан-2016 он

Өнгөрсөн онд манай алба ХАБЭА-н чиглэлийн сургалтад 7,9 сая, бусад мэргэжлийн сургалтад 14,3 сая нийт 22,2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 5 сая төгрөгийн зарцуулалттай буюу 22,4 %-ийн зардлын гүйцэтгэлтэй ажилласан.

2016 онд компанийн сургалтын албанаас зохион байгуулсан нийт 14 удаагийн гадаад дотоод сургалтанд давхардсан тоогоор 982 хүн хамрагдсан байна.



# ХОЁР. 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ТОВЧ

- 2016 онд 753.7 м.тн нүүрс борлуулж, 30.6 тэрбум төгрөгний орлого олсон. Нийт борлуулалтын 73.5%-ийг Дархан, Эрдэнэтийн ДЦС-д нийлүүлсэн байна.
- Эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлэх 1 тонн нүүрсний татваргүй суурь үнийг /2016 оны 1-р сарын 1-нээс/ 6,500 төгрөгөөр нэмэгдүүлж 36,500 төгрөг болгосноор 1 тн нүүрсний борлуулалтын дундаж үнэ урд оноос 3,515.3 төгрөгөөр нэмэгдсэн.
- Компанийн эзэмшилд буй нүүрс олборлох тусгай зөвшөөрөлтэй талбайд илэрсэн алтны шороон ордод 2016 оны 10-р сараас олборлолт явуулж 1,152.7 сая төгрөгний зардал гарган, 1,587.9 сая төгрөгний орлого олж 435.2 сая төгрөгний ашиг олсон.
- Нүүрсний илчлэгийн зөрүүнээс 56.3 сая төгрөг олж, чулуулаг, жингийн зөрүүнээс 379.4 сая төгрөг алдсан.
- 2016 онд компанийн дүнгээр 7,197.2 сая төгрөгний алдагдалтай ажилласан ба нийт алдагдлын 69.0% буюу 4,963.6 сая төгрөгийг валютын ханшны зөрүүнээс хүлээсэн байна.

## 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨГРӨГ /аудитлагдаагүй/

1	Хөрөнгө	Эхний үлдэгдэл	Хувь	Эцсийн үлдэгдэл	Хувь	Зөрүү (+)(-)
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>					
1.1.1	Мөнгө	467,685,582	<u>0.66</u>	783,971,657	<b>1.08</b>	316,286,075
1.1.2	Дансны авлага	6,424,394,149	<u>9.02</u>	4,240,782,214	<b>5.82</b>	(2,183,611,935)
1.1.4	Бусад авлага	2,164,133,571	<u>3.04</u>	4,909,643,815	<b>6.74</b>	2,745,510,244
1.1.5	Бараа материал	1,883,085,283	<u>2.64</u>	2,585,002,886	<b>3.55</b>	701,917,603
1.1.6	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	3,018,293,872	<u>4.24</u>	385,658,149	<b>0.53</b>	(2,632,635,723)
	<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>13,957,592,458</b>	<b><u>19.59</u></b>	<b>12,905,058,723</b>	<b>17.70</b>	<b>(1,052,533,735)</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>					
1.2.1	Үндсэн хөрөнгө	34,330,564,438	<u>48.20</u>	35,109,059,191	<b>48.17</b>	778,494,753
1.2.2	Биет бус хөрөнгө	187,035,223.26	<u>0.26</u>	104,981,945.72	<b>0.14</b>	(82,053,278)
1.2.4	Урт хугацаат хөрөнгө	2,492,949,158	<u>3.50</u>	2,917,949,158	<b>4.00</b>	425,000,000



	оруулалт					
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	45,000,000	<u>0.06</u>	372,078,192	<b>0.51</b>	327,078,192
1.2.7	Бусад эргэлтийн бус хөрөнгө	20,217,509,565	<u>28.38</u>	21,484,138,854	<b>29.47</b>	1,266,629,289
	<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>57,273,058,385</b>	<b><u>80.41</u></b>	<b>59,988,207,342</b>	<b>82.30</b>	<b>2,715,418,957</b>
	<b>Нийт хөрөнгө</b>	<b>71,230,650,844</b>	<b><u>100.00</u></b>	<b>72,893,266,066</b>	<b>100.00</b>	<b>1,662,615,222</b>
3.1	<b>Өр төлбөр</b>					
	<b>Богино хугацаат өр төлбөр</b>					
3.1.1	Дансны өглөг	5,778,912,457	<u>8.11</u>	4,238,869,801	<b>5.82</b>	(1,540,042,656)
3.1.3	Татварын өглөг	2,169,688,925	<u>3.05</u>	3,462,234,450	<b>4.75</b>	1,292,545,525
3.1.5	Богино хугацаат зээл	2,817,579,030	<u>3.96</u>	11,531,089,698	<b>15.82</b>	8,713,510,668
3.1.6	Хүүгийн өглөг	699,566,681	<u>0.98</u>	1,939,660,880	<b>2.66</b>	1,240,094,199
3.1.8	Урьдчилж орсон орлого	10,409,502	<u>0.01</u>	36,083,323	<b>0.05</b>	25,673,821
3.1.9	Бусад богино хугацаат өглөг	8,369,204,750	<u>11.75</u>	6,638,931,749	<b>9.11</b>	(1,730,273,001)
	<b>Нийт богино хугацаат өглөг</b>	<b>19,845,361,347</b>	<b><u>27.86</u></b>	<b>27,846,869,903</b>	<b>38.2</b>	<b>8,001,508,556</b>
	<b>Урт хугацаат өглөг</b>					
3.3.2	Урт хугацаат зээл	13,512,815,258	<u>18.97</u>	8,555,721,346	<b>11.74</b>	(4,957,093,912)
3.3.3	Нөөц өр төлбөр	6,914,167,716	<u>9.71</u>	8,961,654,184	<b>12.29</b>	2,047,486,468
3.3.4	Хойшлогдсон татварын өр	240,518,578	<u>0.34</u>	240,518,578	<b>0.33</b>	-
3.3.5	Бусад урт хугацаат өр төлбөр	1,934,023,802	<u>2.72</u>	1,311,993,487	<b>1.80</b>	(622,030,315)
	<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>	<b>22,601,525,356</b>	<b><u>31.73</u></b>	<b>19,069,887,597</b>	<b>26.16</b>	<b>(3,531,637,759)</b>
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>42,446,886,703</b>	<b><u>59.59</u></b>	<b>46,916,757,501</b>	<b>64.36</b>	<b>4,469,870,798</b>
	<b>Эздийн өмч</b>					
3.3.3	Хувийн өмч	1,017,024,200	<u>1.40</u>	1,017,024,200	<b>1.40</b>	-
	Халаасны хувьцаа	-		-		-
3.3.3	Нэмж төлөгдсөн капитал	23,145,157,851	<u>31.75</u>	23,145,157,851	<b>31.75</b>	
-3.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,222,034,659	<u>15.93</u>	11,613,088,819	<b>15.93</b>	4,391,054,160
	Эзэмшигчийн өмчийн бусад	-		-		
3.3.3	Хуримтлагдсан ашиг	(2,600,452,569)	<u>(13.44)</u>	(9,798,762,306)	<b>(13.44)</b>	(7,198,309,737)
	<b>Нийт эздийн өмч</b>	<b>28,783,764,141</b>	<b><u>35.64</u></b>	<b>25,976,508,564</b>	<b>35.64</b>	<b>(2,807,255,577)</b>
	<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>71,230,650,844</b>	<b><u>100.00</u></b>	<b>72,893,266,066</b>	<b>100.00</b>	<b>1,662,615,222</b>

**ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /ТӨГРӨГ/**

	<b>Үндсэн үйл ажиллагаа</b>	<b>Өмнөх оны дүн</b>	<b>Тайлант жилийн дүн</b>	<b>Зөрүү</b>
1	Орлого	28,155,652,353	32,183,842,967	4,028,190,614
2	ББӨ	20,636,314,775)	(25,854,119,907)	(5,217,805,132)
	<b>Нийт ашиг</b>	<b>7,519,337,577</b>	<b>6,329,723,060</b>	<b>(1,189,614,517)</b>
3	Удирдлага борлуулалтын зардал	4,286,130,096	5,865,454,641	1,579,324,545
	<b>Үндсэн ҮА ашиг</b>	<b>3,233,207,481</b>	<b>464,268,417</b>	<b>(2,768,939,064)</b>
	<b>Үйл ажиллагааны бус</b>			
4	Хүүгийн орлого	18,363,952	10,601,534	(7,762,418)
5	Бусад орлого	627,213,245	484,671,779	(142,541,466)
6	Бусад зардал	(3,009,107,190)	(3,220,491,638)	(211,384,448)
7	Түрээсийн орлого	14,686,983	27,341,291	12,654,308
8	Валютын ханшны ашиг/алдагдал	(1,336,381,259)	(4,963,640,966)	(3,627,259,707)
9	Орлогын албан татвар	233,077,841	1,060,153	(232,017,688)
	<b>Цэвэр ашиг</b>	<b>(685,094,627)</b>	<b>(7,198,309,736)</b>	<b>(6,513,215,109)</b>

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /ТӨГРӨГ/**

		<b>Өмнөх оны дүн</b>	<b>Тайлант жилийн дүн</b>	<b>Зөрүү</b>
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
1.1	Орлого	24,336,628,650	33,042,392,208	8,705,763,558
1.2	Үйл ажиллагааны мөнгөн зарлага	(20,156,789,722)	(28,284,869,366)	(8,128,079,644)
	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4,179,838,928</b>	<b>4,757,522,843</b>	<b>577,683,915</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ</b>			
2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(1,090,211,298)	(443,236,673)	646,974,625
	<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,090,211,298)</b>	<b>(443,236,673)</b>	<b>646,974,625</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
3.1	Зээлийн төлөлт	(1,341,445,500)	(630,000,000)	711,445,500
3.2	Бусад орлого	1,000,000	-	(1,000,000)
3.3	Валютын ханшны	(13,707,995)	(53,505,541)	(39,797,546)
3.4	Санхүүгийн түрээсийн төлөлт	(3,017,888,196)	(3,614,494,553)	(596,606,357)
3.5	Төлсөн ногдол ашиг	-	-	-
3.6	Авсан зээл	840,567,000	300,000,000	(540,567,000)
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,531,474,691)</b>	<b>(3,998,000,095)</b>	<b>(466,525,404)</b>
<b>4</b>	<b>Цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(441,847,061)</b>	<b>316,286,075</b>	<b>758,133,136</b>
	<b>БМ эхний үлдэгдэл</b>	<b>909,532,643</b>	<b>467,685,583</b>	<b>(441,847,060)</b>
	<b>БМ эцсийн үлдэгдэл</b>	<b>467,685,583</b>	<b>783,971,658</b>	<b>316,286,075</b>

## 2016 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн тайлангийн том өөрчлөлтүүдийн талаар

### - НҮҮРСЭЭР АВАХ АВЛАГА

Албан байгууллага, хувь хүн, компаниудаас авах нүүрсний авлага 2016.01.01-нд 6,512.2 сая төгрөг байсан ба үүний 1,045.9 сая төгрөг нь дулааны станцуудаас авах авлага байсан. 2016.12.31-ний байдлаар авлагын нийт дүн 4,381.4 сая төгрөг болсон бөгөөд дулааны станцуудаас авах авлага 635.4 сая төгрөг болж оны эхнээс 410.5 сая төгрөгөөр буурсан байна.

Авлага (компаниар) /сая.төгрөг/

Ангилал	Байгууллага	2016 оны эхний үлдгэдэл	2016 онд авсан	2016 онд төлсөн	Оны эцсийн үлдгэдэл	Үлдгэдэл д эзлэх хувь
ДЦС	Дархан ДЦС	224.1	11,399.8	11,603.0	21.0	0.49
	Эрдэнэт ДЦС	83.2	11,451.4	11,534.6	-	-
	Сэлэнгэ Энерго		438.5	206.2	232.3	5.37
	Дулаан ШГ	738.6	552.5	676.7	614.4	14.21
Томоохон хэрэглэгч	Эрдэнэт УБҮ	4,345.0	4,850.5	6,601.7	2,593.9	59.98
	Эрэл цемент	14.7		3.0	11.7	0.27
	Нако түлш ХХК	362.4	290.6	26.0	627.0	14.50
	Төмөрлөгийн үйлдвэр	30.0	56.7	57.5	29.2	0.67
	Хөтөл цементийн үйлдвэр	18.5		6.3	12.2	0.28
	Гранд Повер ХХК	19.7	21.5	13.0	28.2	0.65
	Ачит ихт ХХК		248.3	228.3	20.0	0.46
Бусад	Ханчин Оргил		34.0	16.6	17.4	0.40
Жижиглэн	Дархан Дельта		287.0	212.4	74.6	1.73
	Дулаан хангай		67.2	38.2	29.1	0.67

### - БУСАД АВЛАГА

Энэхүү дансанд сэлбэг материал болон гэрээт ажил үйлчилгээний гэрээний дагуу төлөгдсөн төлбөрүүд бүртгэгдсэн ба охин компани болох Нако түлш ХК үйл ажиллагаа явуулсантай холбогдуулан 1,450.0 сая төгрөгийг цалин хөлс, эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон авлага бүртгэгдсэнээр өссөн байна.

### - УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

ПРО гаргахтай холбоотой төлөгдсөн байсан 2.0 тэрбум төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрсөнөөр буурсан байна.

### - ҮНДСЭН ХӨРӨНГӨ

778.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд:

Үзүүлэлт	сая төгрөг
2015 оны 12 сарын 31-ээрх үндсэн хөрөнгө /ҮХЭ-ийн элэгдэл орсон/	<b>34,330.5</b>
<b>Нэмэгдсэн үндсэн хөрөнгө</b>	
Барилга байгууламж	-
Тоног төхөөрөмж	421.6
Тээврийн хэрэгсэл	91.0
Тавилга эд хогшил	24.1
Компьютер дагалдах хэрэгсэл	41.2
<b>Нэмэгдсэн үндсэн хөрөнгө</b>	<b>577.9</b>
Дахин үнэлгээ болон бусад дүн	(5,913.5)
Акталсан үндсэн хөрөнгө	(106.9)
2016 оны 12 сарын 31-ээрх үндсэн хөрөнгө	<b>35,109.0</b>
<b>Зөрүү</b>	<b>778.4</b>

- **БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ**

Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн 2016 оны капиталжуулалтийн дүнгээр нэмэгдсэн.

- **НИЙТ ӨР ТӨЛБӨР**

Нийт өр төлбөрийн 59.4%-ийг богино хугацаат өр төлбөр, 40.6%-ийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Нийт өр төлбөр оны эхнээс 4,469.9 сая төгрөгөөр өссөн гол нөлөөлөл нь ханшийн тэгшитгэлийн тооцооноос үүссэн байна.

Үзүүлэлт		Нийт өр төлбөр /сая.төгрөг/		
		2015 он	2016 он	Зөрүү
Богино хугацаат өр төлбөр	Богино хугацаат өр төлбөр /сая.төг/	19,845.4	27,846.9	8,001.5
	Нийт өр төлбөрт эзлэх хувь	46.8	59.4	12.6
	Урд оноос /сая.төг/	7,226.6	8,001.5	774.9
Урт хугацаат өр төлбөр	Урт хугацаат өр төлбөр /сая.төг/	22,601.5	19,069.9	(3,531.6)
	Нийт өр төлбөрт эзлэх хувь	53.2	40.6	(12.6)
	Урд оноос /сая.төг/	(2,670.3)	4,658.2	7,328.5
<b>НИЙТ</b>		<b>42,446.9</b>	<b>46,916.8</b>	<b>4,469.9</b>

- **ДАСНЫ ӨГЛӨГ**


Албан байгууллага, хувь хүн, компаниудад өгөх өглөг 2016.01.01-нд 5,778.9 сая төгрөг байсан бол 2016.12.31-ны байдлаар 4,238.9 сая төгрөг болгож 1,540.0 сая төгрөгөөр бууруулсан байна.

- **ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ӨГЛӨГ**

Татварын өрийн үлдэгдэлд ААНОАТ /266.9 сая төгрөг/, НӨАТ /1,552.2 сая төгрөг/, нөөцийн татвар /710.8 сая төгрөг/ томоохон байрыг эзэлж байна. Нийгмийн даатгалд 877.2 сая төгрөгний өр хуримтлагджээ.



Татвар, нийгмийн даатгалын өглөг



- **БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ**

Зээлийн үлдэгдэл 8,713.5 сая төгрөгөөр нэмэгдсэн. Тайлангийн хугацаанд Си Би Эм ХХК-иас авсан 300.0 мян.\$, Биг Могул ХХК-иас авсан 126.0 сая төгрөгний зээлүүд төлөгдсөн. Зээлийн үлдэгдэлд 684.8 сая төгрөгний ханшийн тэгшитгэл тооцогдсон байна.

ЕХСББанкны 3,333,334 ам долларыг урт хугацаат өр төлбөрөөс богино хугацаат өр төлбөрт шилжүүлэн бичилт хийсэн нь Богино хугацаат зээлийн үлдэгдлийг 8,298.4 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

**Богино хугацаат зээл /мян.дол, сая.төг/**

Байгууллага	2015 он		2016 он		Зөрүү	
	м.дол	сая.төг	м.дол	сая.төг	м.дол	сая.төг
Биг Могул энд энерги		126.0			-	(126.0)
SHG holdings-2	334.0	666.6	334.0	831.5	-	164.9
Могул коул холдингс ХХК	300.0	598.8	300.0	746.9	-	148.1
Си Би Эм ХХК	300.0	598.8			(300.0)	(598.8)
Хай Би Ойл ХХК	414.5	827.4	400.0	1,654.3	(14.5)	826.9
ЕСБХБанк			3,333.3	8,298.4	3,333.3	8,298.4
<b>Дүн</b>	<b>1,348.5</b>	<b>2,817.6</b>	<b>4,367.3</b>	<b>11,531.1</b>	<b>3,018.8</b>	<b>8,713.5</b>

**Хүүгийн өглөг /сая.төгрөг/**

Байгууллага	Ам доллар	сая.төгрөг
SHG holdings-2	110,220.0	274.4
Могул коул холдингс ХХК	41,013.7	102.1
Хай Би Ойл ХХК	83,147.2	207.0
ЕСБХБанк	530,967.8	1,155.4
Эбердигм монгол ХХК		200.7
<b>Дүн</b>		<b>1,939.7</b>

Санхүүгийн байдлаас шалтгаалан ЕСБХБанкинд 2016 оны төлөгдөөгүй хуримтлагдсан хүү 464,110.55 ам\$, алданги 66,857.27 ам\$ байгаа нь хүүгийн өглөгийг 1.24 тэрбум төгрөгөөр өсгөсөн байна.

- **БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГ**

ТиДиБи Лизинг ХХК-с 2014 онд авсан санхүүгийн түрээсийн 2016 оны төлөлт 1.73 тэрбум төгрөг байсан. Энэхүү санхүүгийн түрээс нь 2017 оны 4-р сард төлөгдөж дуусна.

- **УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ**

ЕСБХБанкны төлөгдөх ёстой зээлийг богино хугацаат өр төлбөрт шилжүүлэн бичилт хийсэнээр буурсан ба үлдэгдэл зээлийн ханшийн зөрүү 1.7 тэрбум төгрөгний өөрчлөлтийг оруулсанаар нийт 4.95 тэрбум төгрөгний өөрчлөлттэй гарчээ.

- **НӨӨЦ ӨР ТӨЛБӨР**

Энэ дансанд уурхайн нөхөн сэргээлтийн сангийн капиталжуулалтыг бүртгэсэн.

- **ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ**

2016 онд Пантеон ХХК-иар хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн бөгөөд 4,391.1 сая төгрөгөөр хөрөнгийн үнэ нэмэгдсэн.


## Борлуулалт, борлуулсан бүтээгдэхүүний өртөг

### 2016 оны орлого, зардал, алдагдал /сая.төгрөг/

Үзүүлэлт	2016 он			Урд оны мөн үеэс		
	Орлого	Зардал	Ашиг, алдагдал	Орлого	Зардал	Ашиг, алдагдал
Үндсэн үйл ажиллагаа	32,183.8	25,854.1	6,329.7	4,028.2	5,217.8	(1,189.6)
Нүүрсний	30,596.00	24,701.40	5,894.60	2,440.4	4,065.1	(1,624.7)
Алтны	1,587.80	1,152.70	435.2	1,587.8	1,152.7	435.2
Удирдлага борлуулалт		5,865.5	(5,865.5)	-	1,579.4	(1,579.4)
Үйлдвэрийн бус	82.7	479.5	(396.8)	(6.8)	63.5	(70.3)
Үйл ажиллагааны бус	1,518.2	8,782.9	(7,264.7)	521.8	4,427.8	(3,906.0)
Дүн	33,784.8	40,982.0	(7,197.2)	4,543.2	11,288.5	(6,745.3)

Нүүрсний борлуулалтын орлого урд онтой харьцуулахад 2,440.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Эрчим Хүчний Зохицуулах хорооны 2016 оны 1-р сарын 12-ны өдрийн 48 тоот тогтоолоор эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж буй 1 тн нүүрсний суурь үнийг 6,500 төгрөг /17.8%/ -өөр нэмэгдүүлсэн. Нэгжийн үнэ нэмэгдсэнээр Дархан, Эрдэнэтийн ДЦС-уудад нийлүүлсэн нүүрснээс 3,246.1 сая төгрөгийн нэмэлт орлого олсон.


## 2014-2016 оны Нүүрсний борлуулалтын орлого



## Борлуулалтын хэмжээ /биетээр/

Үзүүлэлт	2015 он	2016 он	Зөрүү
<b>Нийт борлуулалт /м.тн/</b>	<b>758.4</b>	<b>753.7</b>	<b>(4.7)</b>
- Үүнээс: ДЦС-уудад	559.1	553.9	(5.2)
<b>Нийт борлуулалтанд эзлэх хувь</b>	<b>73.7%</b>	<b>73.5%</b>	

## Орлого, зардал, ашиг алдагдал /сая.төгрөг/



**2016 онд нүүрсний илчлэг, жин, чулуулгаас олсон олз, алдсан алдагдал /сая.төг/**

Тайлант онд нүүрсний илчлэгээс 56.3 сая төгрөг олсон боловч, жин, чулуулгаас 379.4 сая төгрөг алджээ. Нүүрсний чанартай холбоотой гомдол, албан бичиг 10 ирсэн.

Нүүрсний үнийг илчлэгтэй холбож өсгөх, буурах зарчмаар тооцоо хийхээр гэрээнд тусгагдсаны дагуу үнээ тооцож ажилласан.

Байгууллага	Илчлэг		Дүн /Мян.төг/	Жин	Чулуулаг	Дүн /Мян.төг/
	Олсон /Мян.төг/	Алдсан /Мян.төг/		Алдсан /Мян.төг/	Алдсан /Мян.төг/	
Дархан ДЦС	19.2	(43.9)	(24.7)	(96.6)	(14.0)	(110.6)
Эрдэнэт ДЦС	193.5	(109.7)	83.8	(58.0)		(58.0)
Жижиглэн		(2.3)	(2.3)	(0.2)	(168.2)	(168.4)
Бусад		(0.5)	(0.5)	(30.9)	(11.5)	(42.4)
<b>Дүн</b>	<b>212.7</b>	<b>(156.4)</b>	<b>56.3</b>	<b>(185.7)</b>	<b>(193.7)</b>	<b>(379.4)</b>

**Ханшийн зөрүүнээс алдсан алдагдал /сая.төгрөг/**

2015.12.31-нд 1 ам.доллар 1,995.51 төгрөгтэй тэнцэж байсан. 2016.12.31-нд 1 ам доллар 2,489.53 төгрөг болж 494.02 төгрөг буюу 24.8%-иар өссөн байна.

Ханшийн тооцоолол /Сая.төг/

Төрөл	Ашиг	Алдагдал	Зөрүү
Мөнгөн хөрөнгө	0.8	(0.1)	0.7
Богино хугацаат зээл	109.6	(898.9)	(789.3)
Санхүүгийн түрээс		(274.2)	(274.2)
Зээлийн хүү	10.3	(271.5)	(261.2)
Урт хугацаат зээл	645.2	(4,292.7)	(3,647.5)
Хөрвөх зээлийн хуримтлагдсан хүү	46.2	(248.2)	(202)
Авлага	264.4	(0.3)	264.1
Ханшийн зөрүүний бодит алдагдал		(54.2)	(54.2)
<b>Дүн</b>	<b>1,076.5</b>	<b>(6,040.2)</b>	<b>(4,963.6)</b>

**1 тн нүүрсний өөрийн өртөг, 1 тн нүүрсний борлуулалтын дундаж үнэ /төгрөг/**


1 тн нүүрсний борлуулалтын дундаж үнэ 3,515.3 төгрөгөөр нэмэгдсэн нь:

- Дарханы ДЦС-ын дундаж үнэ 5,565.8 төгрөгөөр, /278.7 мянган тн нүүрс нийлүүлсэн/,
- Эрдэнэтийн ДЦС-ын дундаж үнэ 5,954.5 төгрөгөөр /284.7 мян.тн нүүрс нийлүүлсэн/ нэмэгдсэнээс хамааралтай боловч бусад хэрэглэгчдэд нийлүүлсэн 1 тн нүүрсний дундаж үнэ 1,601.4 төгрөгөөр буурсан байна.



1 тн нүүрсний өөрийн өртөг 7,258.3 төгрөгөөр өссөн нь Борлуулсан бүтээгдэхүүний өртөг болоод Борлуулалт маркетингийн зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

1 тн нүүрсний өөрийн өртөг, борлуулалтын дундаж үнэ



### Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Үзүүлэлт	2015 он гүйц /сая.төг/	2016 он гүйц /сая.төг/	Зөрүү /сая.төг/
1 Тэсэлгээний зардал	1,089.3	1,242.9	153.6
2 ШТМ	4,233.0	4,340.8	107.8
3 Цахилгаан	1,021.5	1,180.8	159.3
4 Цалин хөлс	4,801.6	5,365.1	563.5
5 НДШ	628.3	699.5	71.2
6 ҮХЭлэгдэл	3,246.9	3,876.9	630.0
7 Сэлбэг хэрэгсэл	1,401.4	1,775.6	374.2
8 Түрээсийн	18.2	1,016.2	998.0
9 Хүүгийн зардал	1,375.4	1,173.5	(201.9)
10 Бусад зардал	2,132.7	2,987.0	854.3
11 Татвар	1,055.5	1,480.7	425.2
12 Бэлэн бүт-ний үлдэгдэл	49.0	(437.6)	(486.6)
13 Капиталжуулсан хөрсний зардал	(416.6)		416.6
<b>ББӨ</b>	<b>20,636.2</b>	<b>24,701.4</b>	<b>4,065.2</b>

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг урд оны мөн үеэс 4,065.2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Өртгийн өсөлтөд нөлөөлсөн гол зардлуудыг авч үзвэл:

## - ТЭСЭЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

2015 онтой харьцуулахад тэсрэх материалын зарцуулалт 153.6 сая төгрөгөөр өссөн нь:

- Үндсэн давхаргын хөрсний хатуулгаас хамааран тэсэлгээ хийгдсэн, цооногт орох нэгжийн зарцуулалт /2015 онд 0.40 кг байсан бол 2016 онд 0.45 кг болж 0.05 кг-аар/ нэмэгдсэн.
- Мөн тэсэлсэн уулын цулын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 90.0 м.м<sup>3</sup>-ээр нэмэгдсэнээс тэсрэх бодисын хэмжээ 101.5 тн-оор өссөн.

## - ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ

Өмнөх оноос нийт 107.8 сая төгрөгөөр өссөн нь:

- 1 литр түлшний үнэ урд оны мөн үеэс 201.2 төгрөгөөр буурсанаар 590.7 сая төгрөгөөр зардал буурсан боловч,
- 2016 онд гүйцэтгэсэн уулын цулын хэмжээ 107.0% буюу 308.5 м.м<sup>3</sup>-ээр нэмэгдсэнтэй холбоотойгоор автосамосвалуудын зарцуулах түлшний хэмжээ 266.1 м.литрээр илүү зарцуулагдаж, үнийн дүнгээр 363.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, мөн бусад ШТМ-н зарцуулалт нэмэгдсэнээр 78.6 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Нэгж ажилд зарцуулагдах түлшний хэмжээ нэмэгдсэнээс 145.3 м.л түлш илүү зарцуулж 198.3 сая төгрөгний зардал нэмэгдэж гарсан байна.

### Түлшний зарцуулалт

	Үзүүлэлт	х/нэгж	2015 он	2016 он	зөрүү
Биетээр	Нийт түлш	м.л	2,510.4	2,935.7	425.3
	Үүнээс: автосамосвал	м.л	1,435.3	1,701.4	266.1
Үнийн дүнгээр	Нийт түлш	сая.төг	3,931.2	4,005.2	74.0
	Үүнээс: автосамосвал	сая.төг	2,245.9	2,317.8	71.9
	Нэгжийн үнэ	төг	1,566.0	1,364.8	(201.2)
Гүйцэтгэсэн ажил	Гүйцэтгэсэн у/цул	м.м <sup>3</sup>	4,380.0	4,688.5	308.5
	Нэгж у/цулд ногдох түлш	л/м <sup>3</sup>	0.3	0.4	0.1

## - ЦАХИЛГААНЫ ЗАРДАЛ /ББӨ/

Тайлант онд 7,133.9 м.квт цаг эрчим хүч зарцуулсан бөгөөд нэгжийн үнэ урд оны мөн үеэс 17.1 төгрөгөөр нэмэгдсэнээс цахилгааны зардал 122.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан.

**Цахилгааны зарцуулалт**

	Үзүүлэлт	х/нэгж	2015 он	2016 он	Зөрүү
Биетээр	Нийт ЦЭХ	м.квт.цаг	6,837.9	7,133.9	296.0
	Үүнээс: цахилгаан экскаватор	м.квт.цаг	3,299.8	3,152.9	(146.9)
Үнийн дүнгээр	Нийт ЦЭХ	сая.төг	1,021.5	1,180.8	159.3
	Үүнээс: цахилгаан экскаватор	сая.төг	488.4	524.9	36.5
	Нэгжийн үнэ	төг	148.4	165.5	17.1
Гүйцэтгэсэн ажил	Гүйцэтгэсэн у/цул	м.м <sup>3</sup>	5,153.4	4,926.4	(227.0)
	у/цулд ногдох ЦЭХ	квт цаг/м <sup>3</sup>	0.6	0.6	0.0

**- СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ЗАРДАЛ**

Сэлбэг материалын үнэ урд оноос дунджаар 20-25%-иар өссөн. Цахилгаан, дизель экскаватор, грейдер, бульдозер, засвар үйлчилгээний сэлбэг материалуудын зарцуулалт өмнөх оноос нэмэгдсэн.

**Сэлбэгийн зарцуулалт /сая.төг/**

Сэлбэгийн нэр	2015 он	2016 он	Зөрүү
Цахилгаан болон дизель экскаваторуудын	381.5	586.9	205.4
Автосамосвалуудын	423.8	328.4	(95.4)
Өрмийн	126.6	75.7	(50.9)
Хүнд механизмын	117.2	296.8	179.6
Дамжлагын тоног төхөөрөмж	33.9	94.1	60.2
ТЭМ 2 болон замын	48.8	36.7	(12.1)
Цахилгааны	69.2	68.7	(0.5)
Үйлчилгээний машины	71.6	54.6	(17.0)
Засвар үйлчилгээний сэлбэг	41.5	99.5	58.0
НБҮ	35.1	32.2	(2.9)
Бусад	51.8	102.0	50.2
<b>Дүн</b>	<b>1,401.0</b>	<b>1,775.6</b>	<b>374.6</b>

**- ТҮРЭЭСИЙН ЗАРДАЛ**

2016 онд автосамосвал түрээсээр ажиллуулж түрээсийн зардалд 822.2 сая төгрөгийн нэмэлт зардал гаргасан бөгөөд Эй Ти Эн ХХК, Хера экуйпмент ХХК, Эрдэнэт Ивээл ХХК-иудтай тээвэрлэлтийн гэрээ хийн хамтран ажилласан байна.

## БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

Үзүүлэлт	2015 он гүйц /сая.төг/	2016 он гүйц /сая.төг/	Зөрүү /сая.төг/
1 ШТМ	72.7	140.3	67.6
2 Цалин хөлс, НДШ	343.7	646.5	302.8
3 ҮХЭлэгдэл	16.7	29.6	12.9
4 Сэлбэг материал	166.1	270.0	103.9
5 Засвар үйлчилгээ	1.4	0.1	(1.3)
6 Хөд хамгаалал	10.7	14.5	3.8
7 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	404.7	528.4	123.7
8 Даатгал	0.9	0.6	(0.3)
9 Түрээс	62.8	292.6	229.8
10 Зар сурталчилгаа	45.4	55.5	10.1
11 Вагон ашиглалт, таталт тавилт	339.4	452.1	112.7
12 Бусад	29.2	45.7	16.5
<b>Нийт</b>	<b>1,493.8</b>	<b>2,475.9</b>	<b>982.1</b>

УБ хот, Дархан хотуудад хийсэн жижиглэн, нүүрс шуудайлан борлуулах ажлын цар хүрээ нэмэгдсэнээр борлуулалт маркетингийн зардал нэмэгдсэн байна.

### 2016 ОНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫГ ДҮГНЭЖ ҮЗЭХЭД:

Улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлаас томоохон хэрэглэгчид үйл ажиллагаа явуулаагүйгээс борлуулалтын орлого төлөвлөсөн хэмжээнээс 26%-иар тасалдсан, эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж буй нүүрсний үнэ нэмэгдсэнээр борлуулалтын орлого 11.9%-иар нэмэгдсэн ч нүүрсний үйлдвэрлэлийн зардал 19.7%-иар өсч, 2016 онд үндсэн үйл ажиллагаанаас 464.3 сая төгрөгний ашигтай ажилласан.

Вальютын ханшны зөрүүнээс 4.9 тэрбум төгрөгний алдагдал хүлээж, 2013-2015 онд нэмэлт хувьцаа гаргах ажлын хүрээнд гарсан 2.0 тэрбум төгрөгийг тайлант жилд зардлаар хүлээн зөвшөөрсөн нь 2016 оны санхүүгийн үр дүнд голлох нөлөө үзүүлсэн.

### ЦААШИД САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛАА ДЭЭШЛҮҮЛЭХИЙН ТУЛД:

1. Нүүрсний үнэ нэмэгдүүлэх асуудлыг ЭХЗХ-нд тавьж алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулах /2017 оны төлөвлөгөөний дагуу Дэд бүтцийн сайдын баталсан Эрчим хүчний нүүрсний үнэ тооцох аргачлалын дагуу тооцсон 1 тн нүүрсний үнэ 45,145.77 төгрөг/
2. Үйлдвэрийн бус үйл ажиллагааны алдагдлыг бууруулах. (Менежментийг сайжруулах)
3. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад анхаарч угаах үйлдвэрийг тогтвортой ажиллуулах, цахилгаан экскаваторуудыг сэргээн босгох гэх мэт техник ашиглалтыг нэмэгдүүлэх боломжит бүх арга хэмжээг авах.
4. Борлуулах боломжтой хөрөнгийн судалгааг гаргаж, хэрэгжүүлэх
5. Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх
6. Зардал бууруулах талаар шат дараатай ажил төлөвлөж, үүний дагуу хэмнэлтийн горимд шилжин ажиллах шаардлагатай байна.

# ГУРАВ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Тус компани, түүний төлөөлөн удирдах зөвлөл, 2016 онд компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлж баримтлан ажиллах чиглэлээр хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндлэн үзэж адил тэгш эрхтэй байх зарчим, компанийн засаглалд оролцох мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрх, хүлээх үүрэг хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэн, ил тод нээлттэй, үр ашигтай зах зээл, хууль тогтоомжийг дээдлэх ёсыг төлөвшүүлэх зарчмыг хэрэгжүүлэн ажилласаар ирлээ.

Компанийн засаглал, ТУЗ-ийн ажил төлөвлөлтөөс эхэлдэг тул 2016 онд доорхи төлөвлөгөөг боловсруулан түүнийг мөрдлөг болгон ажиллаж ирлээ.

Үүнд:

## 1. 2016 ОНЫ ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө
- Компанийн 2016 оны үйл явдлын хуанли
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод /аудитын хороо, цалин урамшуулалын хороо, нэр дэвшүүлэх хороо/-ын 2016 оны ажлын төлөвлөгөө
- Тус компани, компанийн засаглалын хөгжлийн төвтэй “оны шилдэг жилийн тайлан шалгаруулах төсөл”-д хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу “Компанийн 2015 оны жилийн тайлан гаргахтай холбоотой хийгдэх ажлын төлөвлөгөө”
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хийгдэх ажил, цаг хугацааны график.
- Шилдэг жилийн тайлан шалгаруулах үндэсний төслийн чиглэлээр зохиогдох сургалт бусад семинарт оролцох албан тушаалтнуудын нэрс бүхий график хуваарь.
- Ийнхүү төлөвлөлт хийж ажилласнаар компанийн засаглалыг улам сайжруулж байгаа гэж үздэг.



## **2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ДАГУУ МӨРДӨЖ БУЙ ДҮРЭМ ЖУРАМ**

- Компанийн дүрэм
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын үйл ажиллагааны журам
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, түүний ажиллах журам
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам
- Дотоод хяналтын журам
- Ногдол ашгийн журам
- Олон нийтэд мэдээлэл түгээх журам
- Компанийн төлөөлөгчийн газрын дүрэм

Жич: Компанийн ТУЗ-ийн 2016 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хурлын дугаар 06 тогтоолоор “Компанийн ногдол ашгийн журам”, “Олон нийтэд мэдээлэл түгээх журам”-уудын шинэчлэн боловсруулсан хувилбарыг баталж мөрдөн ажиллаж байна.

Уг дүрэм журмуудыг 2016 оны 1 дүгээр сард компанийн засаглалын [www.governance.mn](http://www.governance.mn) портал сайтад байршуулж ил тод мэдээлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд компанийн засаглалын үйл ажиллагаанд дээрхи дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

## **3. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ**

Үүнд: Ил тод нээлттэй байх зарчмыг баримтлан

- Компанийн дүрэм бусад засаглалтай холбогдсон үйл ажиллагааны журмууд.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов, хэлэлцэх асуудал, бүртгэлийн өдөр, саналын хуудас, танилцах материалын жагсаалт зэргийг хуулийн дагуу өдөр тутмын сонин хэвлэлд 2 удаа, телевиз бусад мэдээлэх хэрэгслээр.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг хуралд мэдээлсэн.
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулж компанийн 5 хувиас дээш багц хувьцаа эзэмшигчид, жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, ТУЗ-ийн үйл ажиллагаа, компанийн засаглалын тайлан.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх мэдээлэл. (2016.4.25-ны)
- Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл.

- Сонирхлын зөрчилтэй хэлцэлийн талаарх мэдээлэл.
- Компанийн засаглалын веб сайтад /2016.2.03/ МХБ-ийнТОП-20 индекст бүртгэлтэй компанийн ТУЗ-ийн дарга Б.Батмөнхтэй хийсэн ярилцлага бүхий дэлгэрэнгүй мэдээлэл.
- Компанийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл компанийн ТУЗ-д сонгогдон ажиллаж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төслийг хүргэж тэдний санал зөвлөмжийг шийдвэрт тусган хэрэгжүүлж байдаг юм.
- ХЭХ-д зориулсан тайлан бүхий товхимол



- Оны шилдэг жилийн тайлан шалгаруулах төсөлд зориулсан 2015 оны жилийн тайлан бүхий товхимол



#### 4. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ – КОМПАНИЙН ХУВЬЦАА

##### 2016 оны арилжааны мэдээлэл:

- Компанийн гаргасан хувьцааны тоо, төрөл: 10 170 242 ширхэг энгийн хувьцаа
- 52 долоо хоногийн хувьцааны арилжааны ханш

Арилжаалагдсан ширхэг	21,592.00
Арилжааны үнийн дүн	50,164,695.00
Хувьцааны дундаж ханш	2,323.30
Доод ханш	2,020.00
Дээд ханш	4,000.00

##### “Шарын гол” ХК-ийн хувьцааны

##### 5%-иас дээш багцыг эзэмшигчид

Нийт хувьцаа 10,170,242

д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1	SHG HOLDINGS 3	2,318,451	22,79
2	SHG HOLDINGS 2	2,028,906	19,94
3	NIHAN HOLDINGS	1,598,889	15,72
4	ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК	1,158,520	11,39
5	SHG HOLDINGS 1	1,142,674	11,23
6	MOGUL RESOURCES	1,000,000	9,83

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар “Шарын гол” ХК-ийн хувьцааг нийт 1,049 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бөгөөд үүнээс нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигчийг дээрх хүснэгтээр үзүүлэв.

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигч  
Нэгдмэл сонирхолтой компаниуд**

2016 оны 12-р сарын 31-ний байдлаар

д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь	
1	SHG HOLDINGS 3 S.A.R.L	2,318,451	22,6	ЭС ЭЙЧ ЖИ ХОЛДИНГ 3
2	SHG HOLDINGS 2 S.A.R.L	2,028,906	19,8	ЭС ЭЙЧ ЖИ ХОЛДИНГ 2
3	NIHAN HOLDINGS S.A.R.L	1,598,889	15,6	НИХАН ХОЛДИНГ
4	SHG HOLDINGS S.A.R.L	1,142,674	11,1	ЭС ЭЙЧ ЖИ ХОЛДИНГ 1
5	ELISE HOLDINGS S.A.R.L	124,980	1,2	ЭЛИС ХОЛДИНГ
6	LEXIK HOLDINGS S.A.R.L	94,350	0,9	ЛЭКСИК ЖИ ХОЛДИНГ

**5. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

Үүнд: Компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлыг КТХ-ын дагуу жил бүрийн 4 дүгээр сард зарлан хуралдуулдаг.

- “Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” ТУЗ-ийн 2016.03.11-ний өдрийн 07 дугаар тогтоол гарсан.
- Хурлыг 2016.04.25-нд “Баянгол” зочид буудлын хурлын танхимд хуралдуулах шийдвэр гарч хуралдсан.



*/Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа 2016.4.25/*

- Хуралд:
  - Компанийн 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажил, засаглалын тайланг батлах
  - Компанийн ТУЗ-ийн 2016 оны цалин урамшуулал зардлын төсөв батлах
  - Компанийн ногдол ашгийн тухай асуудал хэлэлцэж зохих шийдвэр гарган энэ тухай мэдээлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц 93,79 хувьтай байв.

- Хурлын материалыг Монгол, Англи хэлээр хэвлүүлж товхимол болгон хуулийн хугацаанд брокер диллерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл явц, шийдвэрийн талаарх мэдээллийг компанийн болон МХБ-ийн цахим хуудсанд байрлуулж, хурлын шийдвэр бүхий материалыг хууль журмын хугацаанд СЗХ, МХБ-д хүргүүлж мэдээлж байв.

## **6. КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ**

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд компанийн тухай хууль, компанийн дүрэм, ТУЗ-ийн ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаа тогтмол явуулж ирлээ.



*/Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2016.11.15/*

- ТУЗ нь оны эхэнд төлөвлөсөн асуудлыг цаг тухайд нь хуралдаж хэлэлцсэн. Гишүүдийн амьдардаг орон зайнаас шалтгаалан онлайн, онлайн бус 2 хэлбэрээр 9 удаа хуралдсан байна.
- 2016 онд ТУЗ-ийн нийт 15 тогтоол гарсан. Үүнд:
  - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай
    - Компанийн ногдол ашгийн журам, олон нийтэд мэдээлэл түгээх журам батлах тухай
    - Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын 2017 оны ажлын төлөвлөгөөний тухай, зэрэг удирдлага зохион байгуулалт, засаглалын асуудлаар 5 тогтоол
  - Үйлдвэрлэлийн 2017 оны бизнес төлөвлөгөөний тухай 2016 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт гаргах тухай зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэлээр 4 тогтоол
  - Эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлэх нүүрсний үнийн тухай
    - Ногдол ашгийн тухай
    - Санхүүгийн жилийн тайлангийн тухай зэрэг асуудлаар 6 тогтоол тус тус гаргаж шийдвэрлэсэн байна

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 онд ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүнтэй ажиллаж компанийн тухай хууль, компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хүрээнд ажиллаж ирснийг тэмдэглэж байна.



## 7. 2016 ОНД АЖИЛЛАСАН КОМПАНИЙН УДИРДЛАГА

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ БҮРЭЛДЭХҮҮН

/2016 он/



**Б.Батмөнх**  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



**Б.Багбаатар**  
ТУЗ-ийн гишүүн  
Нэр дэвшүүлэх хорооны дарга  
Гүйцэтгэх захирал



**Ж.Батболд**  
ТУЗ-ийн гишүүн



**Д.Байлхүү**  
ТУЗ-ийн гишүүн  
Аудитын хорооны дарга  
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн




**Д.Даянбилгүүн**  
ТУЗ-ийн гишүүн  
Цалин урамшуулалын хорооны дарга



**Жеймс Пассин**  
ТУЗ-ийн гишүүн  
Аудитын хорооны гишүүн



**Казин Ник**  
ТУЗ-ийн гишүүн



**Фаррел Кеннет**  
ТУЗ-ийн гишүүн  
Нэр дэвшүүлэх хороо  
Цалин урамшуулалын хорооны  
гишүүн



**Жозеф Найэми**  
ТУЗ-ийн гишүүн  
Аудитын хороо  
Цалин урамшуулалын хорооны  
гишүүн



**Л.Батсуурь**  
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

## КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

/2016 он/



**Б.Батбаатар**  
ТУЗ-ийн гишүүн  
Нэр дэвшүүлэх хорооны дарга  
Гүйцэтгэх захирал



**Б.Отгонзул**  
Бизнес хөгжил хөрөнгө  
оруулалт хариуцсан  
захирал



**Л.Даваасүрэн**  
Ерөнхий нягтлан  
бодогч



**Ж.Эрдэнэбат**  
Ерөнхий инженер



**Т.Шофер**  
Үйлдвэрлэлийн  
менежер

## 8. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ДҮГНЭЛТИЙН БАЙДАЛ

- Тус компани нь “ARAM” төслийн шугамаар МХБ, СЗХ, ТӨХ, КЗХТ хамтран зохион байгуулсан “Оны шилдэг жилийн тайлан шалгаруулах”-д компанийн засаглалын хөгжлийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан оролцсон. Энэ нь Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй олон нийтийн компаниуд болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тайлагнал, ил тод байдлыг сайжруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтыг татах оролцоог хөгжүүлэх чиглэлд жилийн тайлангийн уралдааны зорилго оршиж байсан юм. Энэхүү уралдаанд МХБ-д бүртгэлтэй томоохон бүх компаниуд оролцсон бөгөөд “Шарын гол” ХК эхний 3 байрт шалгарч зохих үнэлэмж бүхий гэрчилгээг гардан авсан юм.



*/Жилийн шилдэг тайлан шалгаруулах төсөлд шалгарч*

*үнэлэмж бүхий гэрчилгээ авсан нь 2016.10.14/*

Тус компани нь 2016 оны ажлын амжилтаар Дархан-Уул аймгийн хэмжээнд шалгарч, Дархан ХАҮТ-ын оны шилдэг аж ахуйн нэгж “ГРАН ПРИ” шагналаар, мөн Дархан-Уул аймгийн “ТОП 5” аж ахуйн нэгжээр, “ТОП-100” аж ахуйн нэгжээр тус тус шалгаран манлайлан ажиллаа.

Ийнхүү тус компани нь уул геологийн хүндрэл, санхүүгийн бэрхшээлтэй байсан ч үүргээ зохих ёсоор биелүүлсний илэрхийлэл юм.







**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Компанийн 2016 оны үйлдвэрлэлийн үйл  
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн  
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11, компанийн дүрмийн 8, 15, 11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2016 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зохих түвшинд явагдсан тул хангалттай, санхүүгийн үйл ажиллагаанд валютын ханшны олз гарзын зөрүү, татвар, НДШ-ийн өглөг нэмэгдсэн, санхүүгийн байдлаас шалтгаалан ЕСБ банканд төлөх зээл, төлөгдөөгүй хуримтлагдсан хүү, алданги зэргээс нийт 7.197,2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан тул хангалттай бус гэж дүгнэсүгэй.
2. 2016 санхүүгийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, санхүүгийн нөхцөл байдлыг зохистой хэлбэрт шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан хэрэгжилтийг улирал бүр ТУЗ-ийн хуралд тайлагнаж байхыг гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Л.Даваасүрэн/ нарт үүрэг болгосугай.
3. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан хэлэлцүүлж батлуулахыг ТУЗ-ийн дарга /Б.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА  Б.БАТМӨНХ

SHARYN GOL JSC  
THE BOARD OF DIRECTORS  
ТТА4951... 2050374



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46.1, компанийн дүрмийн 12 дугаар бүлгийн заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компани 2016 онд 761.9 мянган тонн нүүрс олборлож олборлолтын төлөвлөгөөний биелэлт 86.3%, 753.7 мянган тонн нүүрс борлуулж нүүрс борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 88.1%, 4.340,3 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийж 62.9% гүйцэтгэлтэй ажиллаж, үндсэн үйл ажиллагаанаасаа 464.3 сая төгрөгний ашигтай ажилласан боловч туслах үйл ажиллагаанаас 396.7 сая төгрөг, санхүүгийн үйл ажиллагаанаас 2,301.1 сая төгрөг, ханшийн зөрүүний алдагдалд 4,963.6 сая төгрөг байгаа нь 2016 оны компанийн алдагдалийг 7,197.3 сая төгрөгт хүргэхэд нөлөөлсөн тул 2016 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан мэдээлэхийг гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТМӨНХ